



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 657  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ  
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Л.Амарсанаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-

006021324

2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


### Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Л.Амарсанаа Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Л.Амарсанаагийн мөрийн хөтөлбөр (.....<sup>3</sup>.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Л.Амарсанаад

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Орон нутгийн сонгуульд Булган аймгийн Баян-Агт сумаас  
бие даан нэр дэвшигч Лхагва овогтой Амарсанаа  
Мөрийн хөтөлбөр

**Нэг. Гэр бүлд зориулж хэрэгжүүлэх ажил**

- 1.1 0-5 насны хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах асуудлыг сумын ЭМТ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах, хамтран ажиллах
- 1.2 Сумын болон дээд шатны боловсрол, соёлын байгууллагуудтай хамтран бүх насны иргэдэд зориулсан соён гэгээрүүлэх ажил, үйл ажиллагаа зохион байгуулах

**Хоёр. Хүүхэд хамгааллын чиглэлээр**

- 2.1 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгоход сумын ЗДТГ болон боловсролын байгууллагатай хамтран ажиллах
- 2.2 Дотуур байрны орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр бичиж, санхүүжилтын олох
- 2.3 Үдийн цай, дотуур байрны хоол үйлдвэрлэлд холбогдох хууль журмын хүрээнд тогтмол хяналт тавих, хариуцлагын тогтолцоог нэмэгдүүлэх оролцох
- 2.4 Хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулах, шаардлагатай нөхцөлд багийг шинэчлэх томилох, гишүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх

**Гурав. Залуучуудын талаар**

- 3.1 Улс, аймаг орон нутгаас баримталж буй бодлого чиглэлийн хүрээнд сумандаа ажиллаж буй багш, эмч, төрийн захиргааны албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, суманд шинээр ирж ажиллах залуу төрийн албан хаагчдыг нэмэгдүүлэх
- 3.2 Залуу гэр бүлийн орлогыг нэмэгдүүлэх талаар төрөөс баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах

**Дөрөв. Ахмадын талаар**

- 4.1 Эрүүл, чанартай урт наслахад нь шаардлагатай зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах
- 4.2 Төрд ажиллаад тэтгэвэрт гарсан ахмадуудад байгууллагаас нь үзүүлдэг тусламж, дэмжлэгийг холбогдох хууль журмын хүрээнд нэмэгдүүлэх
- 4.3 “Залуу үедээ зөвлөн туслах, Ахмад үеэс өвлөн суралцах” үйл ажиллагааг төрийн байгууллагууд хэрэгжүүлж хэвших, хамтран зохион байгуулах

**Тав. Эрүүл мэнд**

- 5.1 Сумын Эрүүл мэндийн төвд “Шүдний кабинет” байгуулах, шүдний туслах сувилагч бэлтгэх талаар холбогдох дээд шатны төрийн байгууллагаас дэмжлэг авах, хамтран ажиллах
- 5.2 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон сумын нийт хүн амын эрүүл мэндийг хамгаалах тухай санал, хөтөлбөрийг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх. Дараахь агуулгын хүрээнд, Үүнд:
  - 5.2.1 Хүүхдийн амны хөндийг эрүүлжүүлэх
  - 5.2.2 Зорилтот бүлгүүдэд чиглэгдсэн эрүүл мэндийн боловсролын сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх
  - 5.2.3 Хүүхдийн амтлаг, чихэрлэг, хүнсний хэт их хэрэглээг бууруулах талаар хүүхэд, асран хамгаалагчдад зориулсан тусгай сургалт зохион байгуулах
- 5.3 Хүн бүрийг эрт илрүүлэгт заавал хамруулахад хяналт тавих, судалгаа явуулах, үзлэгийн үр дүнг иргэдэд болон холбогдох мэргэжлийн байгууллагад танилцуулах
- 5.4 Архинд донтох эмгэгтэй иргэдийг эмчлэх, архинаас гаргах ажлыг иргэний гэр бүл, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

#### **Зургаа. Малчдын талаар**

- 6.1 Багийн иргэдийн нийтийн хуралд малчдын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах
- 6.2 Багийн газар нутагт газар тариалан эрхлэх, бусад үйл ажиллагаа явуулахад тухайн багийн иргэдээс санал авах, саналыг харгалзан шийдвэр гаргах тухай санал, заалтыг холбогдох баримт бичигт тусгуулах

#### **Долоо. Боловсрол**

- 7.1 Хүн амыг нийтээр нь соён гэгээрүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх
- 7.2 Мэргэжлийн хичээлийн багш нарын хүртээмж, сургалтын чанарыг дээшлүүлэхэд анхаарч, дээд шатны мэргэжлийн байгууллагад санал хүргүүлэх

#### **Найм. Дэд бүтэц, зам засвар**

- 8.1 Сумын төвд үерийн далан байгуулах саналыг сумын ИТХ, ЗДТГ-ын холбогдох бодлогын баримт бичигт тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих
- 8.2 Сумын төвийн, хорооллын, далангийн дээд доод замыг засварлах саналыг сумын ИТХ, ЗДТГ-ын холбогдох бодлогын баримт бичигт тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих
- 8.3 Хануйн хавцал, хавцлаас баруун тал руу гарах замыг засварлах саналыг сумын ИТХ, ЗДТГ-ын холбогдох бодлогын баримт бичигт тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ААНБ-уудтай хамтран ажиллах
- 8.4 Дэлгүүрийн урд талын машины зогсоолыг засварлах саналыг сумын ИТХ, ЗДТГ-ын холбогдох бодлогын баримт бичигт тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, худалдаа үйлчилгээ эрхлэн явуулдах ААНБ-уудтай хамтран ажиллах

8.5 Албан байгууллага, ААН-н гадуурх хашааг шинэчилж, мал орохооргүй болгох саналыг сумын ИТХ, ЗДТГ-ын холбогдох бодлогын баримт бичигт тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих

**Ес. Байгаль орчин**

9.1 Булаг, шандны эхийг хамгаалах найдвартай, бат бөх, үерийн ус, хог орохооргүй хашаа, хайс хийх саналыг сумын ИТХ, ЗДТГ-ын холбогдох бодлогын баримт бичигт тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих

9.2 Хануйн амралтын нийтийн эзэмшлийн газрын хог хаягдлыг тогтмол зайлуулах талаар сумын ЗДТГ болон холбогдох бусад төрийн байгууллагатай хамтран ажиллах, хяналт хариуцлагыг сайжруулахад анхаарах

**Арав. Төрийн албан хаагчдын талаар**

10.1 Төрийн албан хаагчдын ёс зүй, харьцаа, хандлагыг сайжруулах ажлыг аймгийн Төрийн албаны зөвлөл болон ёс зүйн хороо, холбогдох бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх

10.2 Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулахад аймгийн ЗДТГ, төрийн албаны зөвлөл, эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран ажиллах, дэмжлэг авах